



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/151/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр Утас: 261729 Цахим хаяг: oyuntuguldurg@audit.gov.mn Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн захирал: Г.Баялаг Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага	23
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/414
танай _____-ны № _____-т

МЭДЭЭЛЛИЙН МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН ЗАХИРАЛ Х.ЭНХ-ОРШИХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 706,143.2 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд нэр бүхий 5 ажилтанд нийт 3,676.7 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон;
- Аудитын хэсэгчилсэн тооллогоор үлдэгдэл өртөггүй, 2023 оноос ашиглалтгүй болсон МОНЦАМЭ аппликейшн 77,950.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгөд бүртгэлтэй;
- Урьдчилж төлсөн тооцооны үлдэгдэл 13,685.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 122 дугаар захирамжаар тус агентлагийн бүтцийг 108 орон тоотой байсныг 98 болгож бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 335,125.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, өөрийн хөрөнгөөр 19,675.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус худалдан авсан, хандив тусламжаар 18,952.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан байна.

Бусад асуудал

Тус агентлаг нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,308,646.17	345,498,464.42
33	АВЛАГА	20,991,659.00	190,166,081.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	676,015.93
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	20,991,659.00	39,770,211.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	149,719,854.16
34	УРЬДЧИЛГАА	7,569,230.03	23,926,378.05
34710	Урьдчилгаа тооцоо	7,569,230.03	23,926,378.05
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	7,569,230.03	10,241,378.05
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	13,685,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	98,747,757.14	131,406,005.28
35100	Түүхий эд материал	5,734,514.92	6,227,718.92
35110	Тусгай зориулалттай материал	5,734,514.92	6,227,718.92
35400	Хангамжийн материал	93,013,242.22	125,178,286.36
35410	Бичиг хэргийн материал	49,881,555.82	84,328,745.03
35420	Аж ахуйн материал	10,976,918.00	13,567,476.33
35430	Сэлбэг хэрэгсэл	215,000.00	215,000.00
35470	Бусад хангамжийн материал	31,939,768.40	27,067,065.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,428,390,784.85	1,394,128,038.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,428,390,784.85	1,394,128,038.06
39200	Биет хөрөнгө	1,401,219,791.70	1,378,893,794.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	740,712,971.00	740,712,971.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(280,894,210.08)	(362,275,500.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,872,358.88	38,872,358.88
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,872,358.88)	(38,872,358.88)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,081,677,061.55	2,386,871,872.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,205,334,450.42)	(1,447,729,725.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,538,499.97	97,093,247.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,646,146.72)	(41,633,016.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,745,440.00	3,745,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,042,967.60)	(2,355,087.65)
39217	Ном	4,463,594.00	4,463,594.00
39300	Биет бус хөрөнгө	27,170,993.15	15,234,243.39
39301	Програм хангамж	84,739,084.00	81,876,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(82,759,084.01)	(81,439,416.61)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,747,660.00	92,747,660.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(67,556,666.84)	(77,950,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,555,699,431.02	1,739,626,502.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	675,997.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	675,997.93
41300	Өглөг	-	675,997.93
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	675,997.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,555,699,431.02	1,738,950,504.55
51	Засгийн газрын хувь оролцоо	1,555,699,431.02	1,738,950,504.55
51100	Засгийн газрын оруулсан капитал	923,780,524.52	923,780,524.52
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	923,780,524.52	923,780,524.52
51200	Хуримтлагдсан үр дүн	244,458,647.45	439,993,153.17
51210	Өмнөх үеийн үр дүн	623,316,778.87	256,742,079.64

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	(378,858,131.42)	183,251,073.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	387,460,259.05	375,176,826.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,555,699,431.02	1,739,626,502.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,735,110,139.53	6,976,659,510.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	250,020,779.53	6,976,659,510.58
120	Нийтлэг татварын бус орлого	250,020,779.53	331,137,071.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	225,367,179.53	303,779,168.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	225,367,179.53	303,779,168.18
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,653,600.00	27,357,903.40
122	Тусламжийн орлого	-	6,645,522,439.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,645,522,439.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,370,522,439.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,035,396,639.00
122112	Хөрөнгийн санхүүжилтийн орлого	-	335,125,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	275,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	275,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,485,089,360.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,388,951,589.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,388,951,589.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,137,771.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96,137,771.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,113,968,270.95	6,783,947,233.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,113,968,270.95	6,783,947,233.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,009,000,890.00	5,779,585,317.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,182,351,119.01	3,908,043,271.37
210101	Үндсэн цалин	2,437,331,569.52	1,928,042,574.35
210102	Нэмэгдэл	551,264,338.88	1,493,736,337.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,999,099.14	163,530,456.43
210104	Урамшуулал	141,756,111.47	322,733,902.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	402,576,650.32	495,211,021.67
210201	Тэтгэврийн даатгалын зардал	275,873,558.75	339,594,118.72
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	32,455,713.00	39,949,454.01
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	15,809,576.01	20,776,225.59
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	15,603,736.15	21,846,735.30
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	62,834,066.41	73,044,488.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,662,618.05	34,130,921.10
210301	Гэрэл, цахилгаан	15,801,641.88	19,535,408.00
210302	Түлш, халаалт	15,534,388.49	11,113,098.99
210303	Цэвэр, бохир ус	3,326,587.68	3,482,414.11
2104	Хангамж, бараа материалын зардал	80,188,770.73	89,391,053.74
210401	Бичиг хэрэг	15,857,006.78	11,281,426.61
210402	Тээвэр, шатахуун	11,065,200.00	9,393,734.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,409,167.95	32,133,304.46
210404	Ном, хэвлэл	1,746,000.00	-

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	2,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,011,396.00	34,332,588.67
2105	Нормативт зардал	498,000.00	1,440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	498,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,152,500.00	7,556,100.00
210604	Урсгал засвар	20,152,500.00	7,556,100.00
2107	Томилолт, зочны зардал	126,881,022.73	99,895,237.70
210701	Гадаад албан томилолт	97,542,376.23	79,506,842.70
210702	Дотоод албан томилолт	4,071,424.00	3,070,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,267,222.50	17,318,395.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	621,282,459.96	696,359,724.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	539,505,240.12	580,508,953.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,583,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,888,030.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	651,909.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,078,000.00	15,707,860.00
210807	Газрын төлбөр	95,970.00	95,970.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	72,063,310.84	94,843,440.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,407,749.20	447,557,988.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	118,307,350.00	30,553,138.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	422,100,399.20	417,004,850.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,104,967,380.95	1,004,361,915.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	818,478,489.52
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	818,478,489.52
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	818,478,489.52
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	774,455,119.52
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	44,023,370.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,370,147.00	185,883,426.22
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	5,748,788.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,887,484.00	156,194,638.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,482,663.00	23,940,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	976,597,233.95	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	976,597,233.95	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(378,858,131.42)	192,712,276.93
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,461,203.40
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	1,056,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	8,405,203.40
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(9,461,203.40)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(378,858,131.42)	183,251,073.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,726,213,082.53	6,930,242,293.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,123,722.53	6,930,242,293.16
120	Нийтлэг татварын бус орлого	221,123,722.53	284,719,854.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	221,123,722.53	284,719,854.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	221,123,722.53	284,719,854.16
122	Тусламжийн орлого	-	6,370,522,439.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,370,522,439.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,370,522,439.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,035,396,639.00
122112	Хөрөнгийн санхүүжилтийн орлого	-	335,125,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	275,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	275,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,505,089,360.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,388,951,589.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,388,951,589.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,137,771.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	116,137,771.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,726,213,082.53	6,595,116,493.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,726,213,082.53	6,595,116,493.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,621,245,701.58	5,441,034,723.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,182,351,119.01	3,908,043,289.37
210101	Үндсэн цалин	2,437,331,569.52	1,928,042,574.35
210102	Нэмэгдэл	551,264,338.88	1,493,736,337.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,999,099.14	163,530,456.43
210104	Урамшуулал	141,756,111.47	322,733,920.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	402,576,650.32	495,211,021.67
210201	Тэтгэврийн даатгалын зардал	275,873,558.75	339,594,118.72
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	32,455,713.00	39,949,454.01
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	15,809,576.01	20,776,225.59
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	15,603,736.15	21,846,735.30
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	62,834,066.41	73,044,488.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,662,618.05	34,130,921.10
210301	Гэрэл, цахилгаан	15,801,641.88	19,535,408.00
210302	Түлш, халаалт	15,534,388.49	11,113,098.99
210303	Цэвэр, бохир ус	3,326,587.68	3,482,414.11
2104	Хангамж, бараа материалын зардал	66,932,508.95	63,043,481.46
210401	Бичиг хэрэг	8,834,060.00	5,919,399.00
210402	Тээвэр, шатахуун	11,971,368.00	11,029,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,409,167.95	32,133,304.46
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	2,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,617,913.00	11,711,378.00
2105	Нормативт зардал	498,000.00	1,535,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	498,000.00	1,535,900.00

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,200,388.00	29,195,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,977,900.00	21,639,000.00
210602	Тавилга	21,655,108.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	729,100.00
210604	Урсгал засвар	19,567,380.00	6,827,000.00
2107	Томилолт, зочны зардал	128,352,854.73	101,014,357.70
210701	Гадаад албан томилолт	97,542,376.23	78,546,842.70
210702	Дотоод албан томилолт	5,270,056.00	3,401,520.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,540,422.50	19,065,995.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	615,072,569.12	761,401,953.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	539,505,240.12	594,193,953.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,583,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,888,030.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	651,909.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,078,000.00	15,608,860.00
210807	Газрын төлбөр	95,970.00	95,970.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,853,420.00	146,299,670.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,598,993.40	47,458,698.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,598,993.40	47,458,698.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,104,967,380.95	1,154,081,769.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	968,198,343.68
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	968,198,343.68
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	968,198,343.68
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	774,455,119.52
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	44,023,370.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	99,719,854.16
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	50,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,370,147.00	185,883,426.22
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	5,748,788.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,887,484.00	156,194,638.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,482,663.00	23,940,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	976,597,233.95	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	976,597,233.95	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	335,125,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	335,125,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	335,125,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	335,125,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	335,125,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(335,125,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	387,460,259.05	623,316,778.87	1,934,557,562.44
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923,780,524.52	387,460,259.05	623,316,778.87	1,934,557,562.44
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(378,858,131.42)	(378,858,131.42)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	387,460,259.05	244,458,647.45	1,555,699,431.02
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	12,283,432.19	12,283,432.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923,780,524.52	387,460,259.05	256,742,079.64	1,567,982,863.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(12,283,432.19)	-	(12,283,432.19)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	183,251,073.53	183,251,073.53
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	375,176,826.86	439,993,153.17	1,738,950,504.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,558,465,000.00	5,781,067,319.48	777,397,680.52	88.1
12	Татварын бус орлого	6,558,465,000.00	5,781,067,319.48	777,397,680.52	88.1
120	Нийтлэг татварын бус орлого	185,000,000.00	284,719,854.16	(99,719,854.16)	153.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	185,000,000.00	284,719,854.16	(99,719,854.16)	153.9
122	Тусламжийн орлого	6,373,465,000.00	5,496,347,465.32	877,117,534.68	86.2
122111	Төсвөөс санхүүжих	6,373,465,000.00	5,496,347,465.32	877,117,534.68	86.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,558,465,000.00	5,781,067,319.48	777,397,680.52	88.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,223,265,000.00	5,445,941,519.48	777,323,480.52	87.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,058,453,200.00	5,283,998,093.26	774,455,106.74	87.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,472,644,700.00	3,908,043,289.37	564,601,410.63	87.4
210101	Үндсэн цалин	1,694,040,000.00	1,928,042,574.35	(234,002,574.35)	113.8
210102	Нэмэгдэл	2,212,079,500.00	1,493,736,337.85	18,343,162.15	67.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	201,050,800.00	163,530,456.43	37,520,343.57	81.3
210104	Урамшуулал	365,474,400.00	322,733,920.74	42,740,479.26	88.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	566,153,900.00	495,211,021.67	70,942,878.33	87.5
210201	Тэтгэврийн даатгал	385,069,100.00	339,594,118.72	45,474,981.28	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	45,302,300.00	39,949,454.01	5,352,845.99	88.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,760,000.00	20,776,225.59	1,983,774.41	91.3
210204	Ажилгүйдлийн даатгал	22,873,600.00	21,846,735.30	1,026,864.70	95.5
210205	Эрүүл мэндийн даатгал	90,148,900.00	73,044,488.05	17,104,411.95	81.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,815,800.00	34,130,921.10	4,684,878.90	87.9
210301	Гэрэл, цахилгаан	21,010,300.00	19,535,408.00	1,474,892.00	93.0
210302	Түлш, халаалт	14,035,600.00	11,113,098.99	2,922,501.01	79.2
210303	Цэвэр, бохир ус	3,769,900.00	3,482,414.11	287,485.89	92.4
2104	Хангамж, бараа материалын зардал	55,043,100.00	52,014,081.46	3,029,018.54	94.5
210401	Бичиг хэрэг	4,140,400.00	3,919,399.00	221,001.00	94.7
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,161,400.00	32,133,304.46	28,095.54	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,692,800.00	2,250,000.00	442,800.00	83.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,048,500.00	11,711,378.00	2,337,122.00	83.4
2105	Нормативт зардал	1,613,700.00	1,535,900.00	77,800.00	95.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,613,700.00	1,535,900.00	77,800.00	95.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,855,500.00	5,727,200.00	1,128,300.00	83.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,639,000.00	1,639,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,793,400.00	729,100.00	1,064,300.00	40.7
210604	Урсгал засвар	3,423,100.00	3,359,100.00	64,000.00	98.1
2107	Томилолт, зочны зардал	172,716,400.00	99,074,357.70	73,642,042.30	57.4
210701	Гадаад албан томилолт	151,805,000.00	78,546,842.70	73,258,157.30	51.7
210702	Дотоод албан томилолт	980,000.00	1,461,520.00	(481,520.00)	149.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	19,931,400.00	19,065,995.00	865,405.00	95.7

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	714,078,400.00	657,729,673.96	56,348,726.04	92.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	539,151,400.00	537,886,853.96	1,264,546.04	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,583,500.00	3,583,500.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	900,000.00	900,000.00	50.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	720,000.00	720,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,541,700.00	15,608,860.00	16,932,840.00	48.0
210807	Газрын төлбөр	358,800.00	95,970.00	262,830.00	26.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	135,923,000.00	98,934,490.00	36,988,510.00	72.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,531,700.00	30,531,648.00	52.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,531,700.00	30,531,648.00	52.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,811,800.00	161,943,426.22	2,868,373.78	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	164,811,800.00	161,943,426.22	2,868,373.78	98.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,748,800.00	5,748,788.00	12.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	159,063,000.00	156,194,638.22	2,868,361.78	98.2
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	335,200,000.00	335,125,800.00	74,200.00	99.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	335,200,000.00	335,125,800.00	74,200.00	99.9
222001	Тоног төхөөрөмж	335,200,000.00	335,125,800.00	74,200.00	99.9
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
	Төсвийн байгууллага	1	1	-	
	АЖИЛЛАГСДЫН ТОО	98	98	-	100.0
	Удирдах ажилтан	3	2	1	66.7
	Гүйцэтгэх ажилтан	89	91	(2)	102.2
	Үйлчлэх ажилтан	6	5	1	83.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		275,000,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		275,000,000.0
122	Тусламжийн орлого		275,000,000.0
1221	Хандив тусламж /дотоод/		275,000,000.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		275,000,000.0
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		275,000,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		180,976,630.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		180,976,630.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		157,036,630.0
2104	Хангамж, бараа материалын зардал		11,029,400.0
210401	Бичиг хэрэг		2,000,000.0
210402	Тээвэр, шатахуун		9,029,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		23,467,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		20,000,000.0
210604	Урсгал засвар		3,467,900.0
2107	Томилолт, зочны зардал		1,940,000.0
210702	Дотоод албан томилолт		1,940,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		103,672,280.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		56,307,100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		47,365,180.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		16,927,050.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		16,927,050.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		23,940,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		23,940,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		23,940,000.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		94,023,370.0
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(94,023,370.0)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(94,023,370.0)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг нь “Монгол Улсыг гадаадад сурталчлан таниулах, Монгол Улсын төрийн бодлого, шийдвэрийг дотоод болон гадаадад шуурхай мэдээлэх, Монгол Улсын талаар болон дэлхий дахинд болж байгаа олон улсын үйл явдлын талаарх мэдээллийн урсгалд дүн шинжилгээ хийх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байгууллага нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Монгол Улсын гадаад, дотоод бодлого, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, соёлыг олон улсад таниулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулахад чиглэсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх, гадаадын хэвлэл мэдээллээр Монгол Улсын талаар гарч буй мэдээ, мэдээллийг хөрвүүлэн түгээх;
- Төрийн бодлого, үйл ажиллагаа, хөгжил дэвшил, байгаль, зан заншил, ахуй амьдрал, түүхийн талаар сурталчилгааны нийтлэл, товхимол, нэвтрүүлэг, кино, зураг, цомог, богино хэмжээний видео контент бэлтгэн боловсруулах;
- Холбогдох мэдээлэл, контентыг уламжлалт хэлбэрээр болон нийгмийн сүлжээгээр түгээн таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Монгол Улс, монгол хүний үнэлэмж, үнэ цэнийг тодорхойлсон нэгдсэн ойлголт дүр зураг, үндэсний брэндийг тодорхойлох чиглэлд судалгаа хийх, санал боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- Гадаад сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй дотоод, гадаадын төрийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, харилцааг хөгжүүлэх;
- Монгол Улсын талаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүгнэлт боловсруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага бөгөөд үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын гаргасан тушаал шийдвэр, болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн. Тайлант онд агентлагийн даргын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах

журмын ажлын хэсэг байгуулагдаж, 12 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Агентлагийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/188 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг дагаж мөрддөг бөгөөд бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 183,927.1 мянган төгрөг буюу 12 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	20,991.7	190,166.1	169,174.4
Урьдчилгаа	7,569.2	23,926.4	16,357.2
Бараа материал	98,747.8	131,406.0	32,658.2
Үндсэн хөрөнгө	1,428,390.8	1,394,128.0	(34,262.8)
Нийт хөрөнгө	1,555,699.4	1,739,626.5	183,927.1
Өр төлбөр	-	676.0	676.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,555,699.4	1,738,950.5	183,251.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,555,699.4	1,739,626.5	183,927.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 190,166.1 мянган төгрөг болж, 169,174.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн үйл ажиллагааны орлогыг давуулан биелүүлсэн, нэмэлт

санхүүжилттэй холбоотой үүссэн татаас санхүүжилтийн авлагын өсөлт голлон нөлөөлсөн.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 23,926.4 мянган төгрөг болж, 16,357.2 мянган төгрөгөөр өссөн нь Цахим хуудас хөгжүүлэлт, сонин сэтгүүлийн платформ гүйцэтгэх гэрээний төлбөр урьдчилж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 131,406.0 мянган төгрөг болж, 32,658.2 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад зориулж 338,926.8 мянган төгрөгийн хангамжийн материал, бичиг хэргийн материалын худалдан авалт хийж, 272,314.6 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,394,128.0 мянган төгрөг болж, 34,262.8 мянган төгрөгөөр буурсан бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 335,125.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, өөрийн хөрөнгөөр 19,675.4 мянган төгрөгийн хөрөнгө тус тус худалдан авсан, хандив тусламжаар 18,952.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 9 дүгээр сарын сарын 25-ны өдрийн 446 дугаар тогтоол, Агентлагийн даргын 2025 оны 12 дугаар сарын сарын 17-ны өдрийн А/120 дугаар тушаалыг тус тус үндэслэн 75,511.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, тайлант хугацаанд 417,004.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэрэгтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 183,251.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

Судалгааны үр дүн:

Тус агентлагийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2018-2023 онуудад худалдан авч ашиглаж байгаа, 1,826.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 550.0 мянган төгрөгийн хүний нөөцийн программ, 79,500.0 мянган төгрөгийн өртөгтэй цахим хуудас, 77,950.0 мянган төгрөгийн өртөгтэй МОНЦАМЭ аппликейшн гэсэн программ хангамжууд байна. Тайлант онд программ хөгжүүлэхтэй холбоотой 34,225.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс хөрөнгийн санхүүжилт 913,500.0 мянган төгрөгийн хөрөнгө, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 6,960,073.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 185,000.0 мянган төгрөг буюу нийт зарлагыг 8,058,573.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгө оруулалтын зардлыг 413,500.0 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 510,713.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 924,213.1 мянган төгрөгөөр бууруулж, 7,134,363.2 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь төсвийг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зардлыг 164,800.0 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 411,098.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 575,898.2 мянган төгрөгөөр бууруулж, 6,558,465.0 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,035,396.6 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, 335,125.8 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 284,719.9 мянган төгрөг, нийт 6,655,242.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагаандаа 5,781,067.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 874,175.0 мянган төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,781,067.3 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 773,190.6 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 1,264.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 2,868.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 74.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
70424	Дотоод, гадаад шуурхай мэдээлэл	6,558,465.0	5,781,067.3	777,397.7	88.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,519,301.8	4,746,111.2	773,190.6	87.8
80103	Гэрээгээр ажил, үйлчилгээ	539,151.4	537,886.9	1,264.5	99.8
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	164,811.8	161,943.4	2,868.4	98.3
	Хөрөнгө оруулалт: Тоног төхөөрөмж	335,200.0	335,125.8	74.2	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгасан. Үүнд

- Байгууллагын орон тооны цомхотголын хувьд:** Тайлант онд 108 орон тоо батлагдсан боловч 9 хувийн цомхотгол хийж, гүйцэтгэлээр 98 орон тоотой ажиллаж байна.
- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын хувьд:** унаа хоолны хөнгөлөлтийн зардалд нэг хүнд өдрийн 9.0 мянган төгрөг, нийт 201,050.8

- мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 163,530.5 мянган төгрөг зарцуулж 37,520.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан.
3. **Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүнгийн хувьд:** Гадаад томилолт, арга хэмжээний хувьд нийт 151,805.0 мянган төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 97,612.8 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс гадаад томилолтоор давхардсан тоогоор 28 хүн, 23 удаагийн давтамжтайгаар явж 78,546.8 мянган төгрөг зарцуулсан.
 4. **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн хувьд:** Ажилтан албан хаагчдыг чадавхжуулах сургалт амралтын газар зохион байгуулж, 1,700.0 мянган төгрөгийн заалны түрээс, тээврийн хөлс төлснийг аудитаар зөрчилд тооцож төлбөрийн акт тогтоосон.
 5. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүнгийн хувьд:** Байгууллагын зүгээс уг чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллага, гэрээт ажлын талаар мэдээлэл судалгаагаар ирүүлээгүй. Харин бид аудитын явцад контентын албаны даргатай асуулга ярилцлагын аргаар мэдээлэл авах болоод бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас хэвлэл мэдээллийн байгууллагатай контент бүтээлгэх зорилго бүхий ажил гүйцэтгэх гэрээгээр тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 514,360.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээний шууд гэрээг 21 компанитай байгуулан худалдан авсан явдлыг энэхүү төрөлд хамааруулж ангилсан. Бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан компаниудтай 2024 онд мөн ижил нөхцөлөөр 272,500.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Аудитаар уг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд МИАТ ТӨХК-аас сэтгүүл хэвлэхэд 225,000.0 мянган төгрөг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс контент бүтээх гэрээний төлбөрт 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/46 дугаар тушаал, 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/149 дүгээр тушаалын дагуу нийт 180,976.6 мянган төгрөгийг зарцуулж, 94,023.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Агентлагийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалын дагуу 7 төрлийн 143,080.7 мянган төгрөгийн, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/19 дугаар тушаалын дагуу 500,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийх төлөвлөгөө баталсан.

Гүйцэтгэлээр 335,125.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалтад нээлттэй тендер шалгаруулалт, 111,759.0 мянган төгрөгийн хэвлэлийн цаас, хэвлэлийн хор, харуул хамгаалалтын үйлчилгээний худалдан авалтад харьцуулалтын, босго үнийн дүнгээс бага нийт 31,321.7 мянган төгрөгийн хэвлэлтийн өнгө шүүлт, бичиг хэргийн материал, тээвэр шатахууны худалдан авалтад шууд гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн аудитор Ч.Сэлэнгэ, Р.Оюунбат, Д.Сүхбаатар нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер С.Эрдэнэчимэг, компанийн захирал Г.Баялаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 6,558,465.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 65,584.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1: Шилэн дансны цахим хуудаст 1 мэдээлэл хугацаа хоцроож, 5 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.2 "санхүүгийн тайлан", 2.2.1.6 "төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт", 2.2.3.6 "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14,893.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээгүй, өмнөх оны аудитын шийдвэр хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.”, 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгаж, авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж үзсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, орлого, зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 206,413.0 мянган төгрөгийн 2 төрлийн алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 16,497.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг 67 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	14,893.4	-	-	0.0
Зөвлөмж	2	1,604.0	2	1,604.0	100.0
Нийт дүн	3	16,497.4	2	1,604.0	67.0

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээгүй зөрчлийг арилгах шийдвэрийг хэрэгжүүлээгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Тус байгууллагын өөрийн эрхлэн гаргаж буй сэтгүүл, сонины борлуулалтын үнэ өртгөө бүрэн нөхөхгүй алдагдал үүсгэж байна. Энэ асуудлын хүрээнд сонин сэтгүүлийн өртөг, борлуулалтын үнийн харьцуулсан өртгийн тайлан гаргаж хэвшсэн эсэхийг нягтлан шалгах. Мөн цахим хуудасны сонин сэтгүүл онлайнаар унших платформ хэвийн ажиллаж байгаа эсэхийг нягтлах.
- Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгөөс 32 нэр, төрлийн 73,399.1 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгө хагас жилийн хугацаанд агуулахад хадгалагдаж байна. Үүнийг дараагийн тайлант жилд үйл ажиллагаанд ашиглаж байгаа эсэхийг нягтлах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 706,143.2 мянган төгрөгийн 9 зөрчил илэрсэнд 5,376.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 551,329.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 149,436.7 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 706,143.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 65,584.7 мянган төгрөгөөс давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тайлант онд нэр бүхий 5 ажилтанд нийт 3,676.7 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий 5 ажилтанд зөрүүтэй тооцож олгосон цалинг цалинг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2: Албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг амралтын газар зохион байгуулж, 1,700.0 мянган төгрөгийн заалны түрээс болон тээврийн хэрэгслийн төлбөр төлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралтын газар зохион байгуулсан сургалттай холбоотой заалны түрээс, тээврийн хэрэгслийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант онд шилжүүлсэн 13,685.0 мянган төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 537,644.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд зөвшөөрөл авалгүй зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн 71,486.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.3.1 "төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

Илрүүлэлт 2: Аудитын хэсэгчилсэн тооллогоор үлдэгдэл өртөггүй, 2023 оноос ашиглалтгүй болсон МОНЦАМЭ аппликейшн 77,950.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгөд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогын комисс, Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн цаашид ашиглах эсэх санал боловсруулж, холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 3: Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 696 ширхэг 857,402.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 4: Тус байгууллагын өөрийн эрхлэн гаргаж буй сэтгүүл, сонины борлуулалтын үнэ өртгөө бүрэн нөхөхгүй алдагдал үүсгэж байна. Тухайлбал хятад хэлээр хэвлэн нийтэлдэг "Мөнгү Шяоши Бао" сонины материалын өртөг 3,477 төгрөг, борлуулах үнэ 2,000 төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2 "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн эрхлэн гаргаж буй сонин сэтгүүлийн өртгийг үнэн зөв, иж бүрэн тооцоолж үр ашигтай ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Аудитын биет горимын хүрээнд хэсэгчилсэн тооллого хийхэд биет бус хөрөнгөөр бүртгэгдсэн montsame.mn сайтын цахимаар сэтгүүл унших хэсэг нь ажиллахгүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим сайт хөгжүүлэхээр байгуулсан гэрээний биелэлтийн хүрээнд цахимаар сонин, сэтгүүл унших платформыг хэвийн ашиглалтад оруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 537,644.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан компаниудтай 2024 онд мөн энэхүү нөхцөлөөр 253,400.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	1	537,644.8			1	537,644.8						
2	Тайлант онд 13,685.0 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	13,685.0			1	13,685.0						
3	Нэр бүхий 5 ажилтанд 3,676.7 мянган төгрөгийн цалин, урамшуулал илүү олгосон.	1	3,676.7	1	3,676.7								
4	Тайлант хугацаанд зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах зөвшөөрөл авалгүй 71,486.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	71,486.7					1	71,486.7				

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Аудитын биет горимын хүрээнд хэрэгжүүлсэн хэсэгчилсэн тооллогоор үлдэгдэл өртөггүй, 2023 оноос ашиглалтгүй болсон МОНЦАМЭ аппликейшн биет бус хөрөнгөд бүртгэлтэй байна.	1	77,950.0					1	77,950.0			
6	Аудитын биет горимын хүрээнд хэсэгчилсэн тооллого хийхэд биет бус хөрөнгөөр бүртгэгдсэн montsame.mn сайтын цахимаар сэтгүүл унших хэсэг нь ажиллахгүй байна.	1	0					1	0			
7	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 696 ширхэг 857,402.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	1	0					1	0			
8	Тус байгууллагын өөрийн эрхлэн гаргаж буй сэтгүүл, сонины борлуулалтын үнэ өртөгөө бүрэн нөхөхгүй алдагдал үүсгэж байна. Тухайлбал хятад хэлээр хэвлэн нийтэлдэг "Мөнгү Шяоши Бао" сонины материалын өртөг 3,477 төгрөг, борлуулах үнэ 2,000 төгрөг байна.	1	0					1	0			
9	Ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг амралтын газар зохион байгуулж, төсвийн хөрөнгийг	1	1,700.0	1	1,700.0							

Мэдээллийн Монцамэ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үр ашиггүй зарцуулсан байна.												
Дүн	9	706,143.2	2	5,376.7	2	551,329.8	5	149,436.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 171 мэдээлэл оруулбал зохистойгоос 165 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа хоцроосон, оруулах хугацаа нь болоогүй 5 мэдээлэл байна.	1	0			1	0
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
2	Үндсэн хөрөнгөөр бүртгэсэн 2 авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээ гараагүй гэсэн өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлага хэрэгжээгүй байна.	1	14,893.4	1	14,893.4		
	Нийт дүн	2	14,893.4	1	14,893.4	1	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 494/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/151/КА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 537,644,800.00 /Таван зуун гучин долоон сая зургаан зуун дөчин дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, өмнөх онд тус компаниудтай мөн ижил нөхцөлөөр 253,400,000.00 /хоёр зуун тавин гурван сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн захирал /Х.Энх-Орших/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Г.БАЯЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-90.Docx

1526181043



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 495/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/151/КА -СТА -ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөөр бүртгэсэн 14,893,427.00 /Арван дөрвөн сая найман зуун ерэн гурван мянга дөрвөн зуун хорин долоон/ төгрөгийн анхны өртөгтэй 2 авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээгүй, өмнөх аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэр хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авто машины граж нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээгүй байгаа зөрчлийг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн захирал /Х.Энх-Орших/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Г.БАЯЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 496/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/151/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 13,685,000.00 /Арван гурван сая зургаан зуун наян таван мянган/ төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн захирал /Х.Энх-Орших/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.БАЯЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 100/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/151/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэр бүхий 5 ажилтанд нийт 3,676,709.64 /Гурван сая зургаан зуун далан зургаан мянга долоон зуун есөн/ төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилчдад зөрүүтэй тооцож олгосон нийт 3,676,709.64 /Гурван сая зургаан зуун далан зургаан мянга долоон зуун есөн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн захирал /Х.Энх-Орших/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.БАЯЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 99/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/151/КА - СТА - ТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг амралтын газар зохион байгуулж, 1,700,000.00 /Нэг сая долоон зуун мянган/ төгрөгийн заалны түрээс болон тээврийн хэрэгслийн төлбөр төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж, амралтын газар сургалт зохион байгуулсан 1,700,000.00 /Нэг сая долоон зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн захирал /Х.Энх-Орших/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХҮЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Г.БАЯЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-59.Docx

1526200052